



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 384

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд өөрчлөлт  
оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Үндэсний аудитын газраас “Ховд дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн аудитлагдсан тайланд эзэмшигчийн өмч дэх төрийн өмчийн дүнг 13,285,935,498.23 (арван гурван тэрбум хоёр зуун наян таван сая есөн зуун гучин таван мянга дөрвөн зуун ерэн найман төгрөг хорин гурван мөнгө) төгрөг байхаар тусгасны дагуу эздиж өмч дэх төрийн өмчийн дүнг бууруулахыг зөвшөөрсүгэй.

2. “Ховд дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 5.1-д “Компани нь “нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 163,467,524 (нэг зуун жаран гурван сая дөрвөн зуун жаран долоон мянга таван зуун хорин дөрвөн) ширхэг энгийн хувьцаатай” гэснийг “нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 132,859,355 (нэг зуун гучин хоёр сая найман зуун тавин есөн мянга гурван зуун тавин таван) ширхэг энгийн хувьцаатай” гэж өөрчлөн найруулсугай.

3. “Ховд дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 5.1-д төрийн өмчит хувьцаат компанийн эзэмшигчийн өмч дэх төрийн өмчийн дүнд орсон өөрчлөлтийг холбогдох байгууллагад бүртгүүлэхийг компанийн Гүйцэтгэх захирал Д.Энхсайханд үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Бодлого, төлөвлөлт удирдлагын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэд даалгасугай.

ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА

